



**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

**Улаанбаатар хот  
2016 оны 04 сарын 04-ны өдөр**

## **“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

2016 оны 03 дугаар сарын  
18-ны өдөр

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж батлах.
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдлүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 04 дугаар сарын 04-ны өдрөөр эчнээгээр санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн өдрийг 04 дүгээр сарын 28-ны өдрийн өглөөний 10:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2016 оны 04 сарын 01-ны өдрөөс эхлэн “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөгчийн газар болон харьяалагдах брокер диллерийн компаниар дамжуулан танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15,  
Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхим,

Лавлах утас:99068713, 99000249

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж батлах.
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдлүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР  
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ  
БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. “Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайлан
2. “Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон 2016 оны зардлын төсөв
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдлүүлэх асуудлын танилцуулга
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Д/д	Хурлын дэг	Хугацаа, цаг минут
1.	Хурлын ирц бүртгэх /Тооллогын комисс/	13.00-14.00 цагт
2.	Хурлын ирц мэдээллэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут
4.	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5.	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6.	Хуралд оролцогсдын асуулт хариулт	Хүн тус бүрээр 5 мин
7.	Хуралд оролцогсдын санал дүгнэлт	Хүн тус бүрээр 5 мин
8.	Завсарлага	15 мин
9.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 мин
10.	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах	Асуудал тус бүрээр 15 минут
11.	Хурлын ажиллагааг хаах	5 мин



ШИВЭЭ ОВОО

“ШИВЭЭ-ОВОО”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчидийн ээлжит  
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11.5.1 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдуулахаар тогтосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтсугай.

2.1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах.

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

2.4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж батлах.

2.5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдлүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

3. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөр тогтоосугай.

5. Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссын дарга:

О.Отгонбаатар / Гүйцэтгэх захирал /

Гишүүд:

Ж.Батмөнх /Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга /

О.Чинхүсэл / ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /

А.Энхгэрэл / Хуулийн зөвлөх /

Д.Золзаяа / Захиргааны мэргэжилтэн /

Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Тооллогын комиссын дарга: С.Одбаяр / ерөнхий нягтлан бодогч /

Гишүүдэд: Х.Дашжаргал / төлөөлөгчийн газрын дарга /

С.Боргил / ХХХ-ийн мэргэжилтэн менежер /

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар "Шивээ Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Ариунболдыг томилсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, байршил, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, бүртгэлийн өдөр, хурал зохион байгуулах комиссын талаарх мэдээлэл бүхий зарыг 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор өдөр тутмын хоёроос доошгүй сонинд нийтлүүлж, "Хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудсанд байршуулсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийг 2016 оны 04 сарын 01-ны өдрөөс эхлэн "Шивээ Овоо" ХК-ийн Төлөөлөгчийн газар болон харьяалагдах брокер диллерийн компаниар дамжуулан танилцахыг дурдсугай.

9. Хувьцаа эзэмшигч нь ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар урьдчилан санал өгч болох бөгөөд саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг доорх байдлаар тус тус тогтоосугай. Үүнд:

- Саналын хуудас хүлээн авах газар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Багануурын төлөөлөгчийн газрын 101 тоот өрөөнд тооллогын комисс хүлээн авна. утас:458940,
- "Саналын хуудас" –ыг хүлээн авах сүүлчийн өдрийг харьяалагдах брокер диллерийн компаниар дамжуулан хурал хуралдах өдрөөс нэг хоногийн өмнө байхаар тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудлаар "Санал авах хуудас"-ны загварыг гуравдугаар хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох "Санал авах хуудас"-ны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

11. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.АРИУНБОЛД

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар  
санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн /брокер, диллерийн компани/

Брокерийн овог ..... нэр .....

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол”ХХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,		
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон 2016 оны зардлын төсвийг батлах		
3	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг батлах		
4	Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдлүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх		

Брокерийн ...../...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигчийн ...../...../

гарын үсгийн тайлал

2016 оны .... сарын ....-ны өдөр



“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар  
ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо:.....Кумулятив саналын тоо .....

Бүртгэсэн / брокер, диллерийн компани /.....

Брокерийн овог .....нэр.....

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол”ХХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
	Ердийн гишүүн	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
	Хараат бус гишүүн	
1		
2		
3		
4		

Брокерийн ...../...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигч...../...../

гарын үсгийн тайлал


2016 оны ..... –р сарын .....өдөр

# “ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

## 1. Уулын үйлдвэрлэлийн талаар

2015 оны гүйцэтгэлээр 7,042.9 мянган.м<sup>3</sup> хөрс хуулж (тээвэртэй 4,955.5 м.м<sup>3</sup>, тээвэргүй 2,087.4 м.м<sup>3</sup>) 1,736.5 мянган тонн нүүрс олборлон 1,817.7 мянган тонн нүүрс борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөө 82.0 хувь, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө 83.5-102.4 хувийн биелэлттэй байна. Тээвэртэй хөрс хуулалт 92.1 хувь, тээвэргүй хөрс хуулалт 65.0 хувийн тус тус биелэлттэй байна.

2015 онд 2313,3 мян.тн нүүрс олборлон борлуулах түүний дотор “ДЦС-IV” ТӨХК-д 1750.0 мян.тн, бусад орон нутгийн хэрэглэгчдэд 563,3 мян тн нүүрс тус тус борлуулах төлөвлөгөөтэй ажилласнаас 1817,7 мянган тонн нүүрс борлуулж борлуулалтын төлөвлөгөө 16,5 хувиар тасарсан байна. Борлуулалтын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь:



1. “ТЭЦ-4” ТӨХК нь захиалгат нүүрснээс 30,0 мян тн нүүрс дутуу авахаар болж гэрээнд өөрчлөлт оруулсан.

2. Амгалангийн ДС нь 1, 4-р улиралд нийт 360,0 мян тн нүүрс нийлүүлэхээр төлөвлөсөн боловч нүүрсний бутармаг анхны ТЭЗҮ-ээс өөрчлөгдснөөс нийлүүлж чадаагүй болно.

3. Орон нутгийн хэрэглэгчдийн хувьд 2014 оны нүүрсний төлбөрийг хийгдээгүйгээс их хэмжээний авлага үүссэн. Авлага авахын тулд нүүрс

нийлүүлэлтийг хязгаарласнаас тус компаниудад 105,0 мян тн нүүрс дутуу нийлүүлсэн зэргээс шалтгаалан борлуулалтын төлөвлөгөө тасарсан.

## 2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг биелүүлэх, талаар:


2015 оны бизнес төлөвлөгөөгөөр нийт 49,225.8 сая төгрөгийн борлуулалт хийж 55,897.5 сая төгрөгийн зардал гарган 6,671.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн.

2015 онд үндсэн үйл ажиллагаанаас 37,759.7 сая төгрөгийн орлого олж 33,925.9 сая төгрөгийн зардал гарган 3,833.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж, үйлдвэрлэлийн бус


үйл ажиллагаанаас 4003.2 сая төгрөгийн орлого олж 7186.9 сая төгрөгийн зардал гарган 3183.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллан, нийт дүнгээрээ 650.1 сая төгрөгийн ашигтай ажиллаа.

### Борлуулалтын хэмжээ 2012-2015 онд

Биет хэмжээгээр



Мөнгөн дүнгээр:



ДЦС-4 компанид нийлүүлсэн нүүрсний жилийн дундаж илчлэг 2945.7 ккалори/кг буюу нийлүүлэх нүүрсний стандарт илчлэг 3030 ккал/кг нийт дүнгээрээ 297.1 сая төгрөгийн


олох боломжоо алдсан байна. Олборлосон нүүрсний илчлэг 2015 оны 1-р улирлын байдлаар нүүрсний дундаж илчлэг 2916.0 ккал/кг, 2-р улиралд 2925.0 ккал/кг, 3-р улиралд 2969.0 ккал/кг, 4-р улиралд 2972.7 ккал/кг гарсан байна.

Хэрэглэгчдийн хувьд нийт нүүрсний 90.9 хувийг буюу 1,652.1 мянган тонн нүүрс ДЦС-4 ХК-д борлуулсан бөгөөд Бор-Өндөр УБҮ 32.4 мянган тонн, УБТЗ 34.3 мянган тонн, Дорноговийн ДС 34.4 мянган тонн тус тус худалдан авсан. Хэрэглэгчдээр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэсээ ДЦС-4 ХК-ийн худалдан авалт 97.9 мянган тонноор, Амгалан ДС 360.0 мянган тонноор, Налайх ДС 30.1 мянган тонноор, Дорноговийн ДС 3.76 мянган тонноор, УБТЗ-ийн худалдан авалт 0.2 мянган тонноор, Бор-Өндөрийн УБҮ-ийнх 2.1 мянган тонноор тус тус буурсан байна.

Нийт нүүрснийхээ 97.5 хувийг доорх 6 хэрэглэгчид борлуулсан байна. Нүүрс борлуулалтын зах зээлийн томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй нүүрсний хэмжээг үзүүлбэл / мянган тонноор /


ДД/д	Хэрэглэгчид	2014 оны гүйцэтгэл	2015 оны төлөвлөгөө	2015 оны гүйцэтгэл	Дүнд эзлэх хувийн жин
1.	ДЦС-IV ТӨХК	1831.4	1750.0	1652.1	90.9
2.	УБ Төмөр зам	36.5	34.5	34.3	1.9
3.	Бор өндөр УБҮ	37.7	34.5	32.4	1.8
4.	Дорноговь ЭХНҮ	33.7	38.16	34.4	1.9
5.	Төв Чандмань ЭХНҮ	3.8	6.0	0	
6.	Налайх ДС	20.7	36.0	5.9	0.3
7.	Говьсүмбэр	3.8	13.1	12.2	0.7
8.	УС-15 ДС	0	360.0	0.0	0
9.	Бусад	46.1	41.04	46.5	2.6
10.	Дүн	2013.7	2313.3	1817.8	100.0

2015 оны гүйцэтгэлээр нүүрс борлуулалтын нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 28.7 хувь буюу 15,069.3 сая төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.2 хувиар буюу 449.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлт гарч байна. Энэ хугацаанд нэг тонн нүүрсийг 21,551.0




төгрөгөөр олборлон 19,371.4 төгрөгөөр борлууллаа. Нүүрс борлуулалтын нэгж тутмаас 1456.7 төгрөгийн, өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын нэгж үнэ дундажаар 2869.1 төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн уулын цулын нэгжийн өртөг төлөвлөсөн хэмжээнээс 1.3 хувь буюу 412.6 төгрөгөөр,

өнгөрсөн оны мөн үеийн түвшингөөс 136.3 төгрөгөөр тус тус буурсан.



**Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг**  
/мян.төг-өөр/



"ШИВЭЭ-ОВОО" ХК -ИЙН 2015 ОНЫ ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ							
Дд.	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 оны гүйцэтгэл	2015 он		Харьцуулсан %	
				төлөвлөгөө	гүйцэтгэл	төл-тэй	өнгөрсөн оны мөн үетэй
<b>I</b>	<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>						
1	Нүүрс олборлолт	м.тн	1,939.1	2,313.3	1,736.8	75.1	89.6
	Нүүрс борлуулалт	м.тн	2,013.7	2,313.3	1,817.8	78.6	90.3
	Хөрс хуулалт	м.м³	6,774.8	9,415.8	7,043.0	74.8	104.0
	<b>Нийт уулын цул</b>	<b>м.м³</b>	<b>12,108.8</b>	<b>15,082.1</b>	<b>10,923.7</b>	<b>72.4</b>	<b>90.2</b>
<b>2</b>	<b>Нийт орлого:</b>	<b>м.төг</b>	<b>40,620,438.5</b>	<b>49,225,806.8</b>	<b>41,762,947.0</b>	<b>84.8</b>	<b>102.8</b>
	Үүнээс Цэвэр борлуулалт	м.төг	36,163,584.5	49,070,431.8	37,759,707.2	77.0	104.4
	Нүүрсний илчлэгийн зөрүүгийн орлого	м.төг	-	2.0	4.0	200.0	#DIV/0!
<b>3</b>	<b>Нийт зардал:</b>	<b>м.төг</b>	<b>36,472,259.0</b>	<b>55,897,524.8</b>	<b>41,112,848.9</b>	<b>73.6</b>	<b>112.7</b>
	Удирдлагын зардал	м.төг	2,099,794.0	2,342,023.0	1,663,622.0	71.0	79.2
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>м.төг</b>	<b>2,048,385.5</b>	<b>(6,671,718.0)</b>	<b>650,098.1</b>	<b>(9.7)</b>	<b>31.7</b>
5	Төсвийн төлбөрт:	м.төг	6,379,018.6	8,283,492.6	6,383,459.6	77.1	100.1
	а) орлогын татвар	м.төг	-	-	65,009.8	#DIV/0!	#DIV/0!
	б) НӨАТ	м.төг	3,616,358.4	4,907,043.2	3,786,064.2	77.2	104.7
	в) Бусад татвар, төлбөрүүд	м.төг	2,762,660.1	3,376,449.4	2,532,385.6	75.0	91.7
6	Нийт авлага	м.төг	4,544,806.2	7,375,493.5	3,484,263.0	47.2	76.7
7	Нийт өглөг	м.төг	88,822,629.0	84,501,262.9	93,872,175.4	111.1	105.7
	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	38,861,359.2	30,789,384.8	49,386,086.3	160.4	127.1
8	Сарын дундаж цалин	м.төг	1,176.4	1,562.7	1,072.6	68.6	91.2
9	1тн нүүрсний өөрийн өртөг	төг	14,415.1	23,706.5	18,663.5	78.7	129.5
10	1тн нүүрсний дундаж үнэ	төг	17,959.1	21,212.3	20,772.6	97.9	115.7
11	1м³ уулын цулын өртөг	төг	3,128.1	3,480.8	3,426.4	98.4	109.5
12	Нийт цалингийн сан	м.төг	7,270,151.4	10,782,541.1	6,821,853.9	63.3	93.8
13	Ажиллагчдын тоо	хүн	515	595	530	89.1	102.9
14	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	1.12	1.12	0.93	83.2	82.7
15	ХО ба ТЗБАХэмжээ	м.төг	4,196,830.0	28,118,504.0	2,948,514.5	10.5	70.3
<b>II</b>	<b>Түлш эрчим хүчний найдвартай байдал</b>						
1	Аваар, осол / техникийн /	тоо	-	-	-	#DIV/0!	#DIV/0!
2	Хөрс хуулалтын коэффициент	м³/тн	0.1	2.1	4.1	197.3	7,343.2
3	Ус шүүрүүлэлт	м.куб	3,725.5	4,300.0	3,487.8	81.1	93.6
4	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	15,892.1	44,364.0	56,366.0	127.1	354.7

### 3. Компанийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, техник технологийн талаар:



“Шивээ-Овоо” ХК нь төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрээр компанийн бүтэц 6 хэлтэс, 3 алба, 8 хэсэг, 1 охин компани, 595 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар батлагдсанаас 2015 онд 537 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан.


2015 онд байнгын ажлын байранд нийт 69 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ шинээр байгуулсан. Мөн онд 55 ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хуулийн дагуу цуцалсан байна. Говь сүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтэй хамтран ажиллах гэрээний дагуу ажлын байранд шаардагдах онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 23 залуу ажилтанд “Уулын цахилгаан механик” мэргэжил эзэмшүүлсэн.

2015 оны 12 дугаар сарын сүүлээр өөрийн хөрөнгөөр 12-р байрны засварын ажлыг дуусган нийт 48 ажилтныг хувийн орон сууцаар ханган ажиллаж байна. 2015 онд орон сууцны хангамжийн асуудлаар 31 уурхайчинд орон сууц олгож, 57 уурхайчны орон сууцны нөхцөлийг сайжруулсан. Ингэснээр 2-оос дээш жил ажиллаж байгаа бүх ажилтнууд тохилог орон сууцаар хангагдсан.

Тус компани 2015 онд иргэд болон ажилтнуудаас нийт 659 өргөдөл хүлээн хуулийн хугацаанд шийдвэрлэснээс 426 өргөдөл буюу 64.6 %-ийг хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн.

Компанийн техникийн шинэчлэлийг уул уурхайн зориулалт бүхий өндөр бүтээлт уулын болон тээврийн хэрэгслүүдээр хэрэгжүүлэх, борлуулалтын дараах үйлчилгээ болон засвар үйлчилгээний зардлууд, ашиглалтын явц дахь зардал, сэлбэг хэрэгслийн нийлүүлэлт зэрэг үйлчилгээ нөхцлүүдийг харгалзан парк бүрдүүлэлтийг нэг төрлийн буюу нэг улс, брендийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээр хийх бодлогыг баримтлан ажиллаж байна. Машин механизмын ашиглалтын байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.





Шивээ-Овоо ХК нь 2015 онд хөрөнгө оруулалт техник зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд доорх хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

1. Олон утгуурт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн хосолсон цахилгаан системийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ТЭЗҮ-ийг Уул Уурхайн хүрээлэн, Фамур компаниудтай хамтран боловсруулж УУЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн зөвлөлөөр оруулж батлуулаад байна. Энэ ажил хэрэгжснээр техникийн онолын бүтээлийг 40%-аар тооцоход жилд дундажаар 4,4 сая м3 хөрсийг тээвэрлэж овоолго үүсгэнэ. Ингэснээр уурхайд одоогийн хөрс хуулалтын коэффициентоор бодоход 1,2 сая тн нүүрс нээх, компаний борлуулалтын орлогыг 25,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг олгоно.
2. Нүүрс тээвэрлэх конвейерын систем, хатаах үйлдвэрийн эх үүсвэрийг салгах ажил
3. Аваарын дизель генератор суурилуулах ажил
4. Үйлдвэрлэлийн ба иргэний 6 барилгын өргөтгөл, засвар, цахилгаан хангамж, инженерийн байгууламжийн ажлыг 1.9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Үйлдвэрлэлийн зардал зах зээлээс хамааран жилээс жилд өсч байгаа байдал, нөгөө талаас хөрсний хуримтлагдсан хоцрогдолыг багасгах, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулахын тулд технологийн шинэчлэл хийх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага тулгарсан учраас энэ хүрээнд 2015 онд нүүрс тээвэрлэх конвейерын систем, хатаах үйлдвэрийн эх үүсвэрийг салгах ажлын бүтээн байгуулалтанд 1,3 тэрбум төгрөг, хатаах үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний найдварт ажиллагааг сайжруулах зорилгоор аваарын дизель генератор суурилуулах ажлын бүтээн байгуулалтанд 160,0 сая төгрөг зарцуулаад байна.

Энэ хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр нүүрсний чанарын үзүүлэлтүүд сайжирч, илчлэг 300-400 ккалориор нэмэгдэж илчлэгийн зөрүүнээс жилдээ 900 сая орчим төгрөгийн нэмэлт орлого олох, нүүрс тээвэрлэлтийн талын зайг багасгах, ингэснээр үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, нүүрсний

автосамосвалиудын ажиллах тоог хэмнэх, хуваарилалт хүрэлцээг сайжруулах боломжийг нэмэгдүүлэх зэргээр үйлдвэрлэлд эерэгээр нөлөөлнө.

5. 1998 оноос хойш хийгдээгүй техникийн шинэчлэлийг үргэлжлүүлэн 55тн даацтай Белаз 7555 маркийн 4 өөрөө буулгагч автосамосвалыг 4,4 тэрбум төгрөгөөр,
6. 9,3м3 отвал бүхий гинжит бульдозер Dressta-T25-ыг 1,2 тэрбум төгрөгөөр тус тус худалдан авч ашиглалтанд оруулсан.
7. 2015 оны бизнес төлөвлөгөөнд худалдан авахаар тусгагдсан ЭКГ-10И цахилгаан экскаватор 1ш, 136тн даацтай цахилгаан технологийн автосамосвал 3ш-ыг худалдан авах тендерийг зарлаж хуулийн дагуу шалгаруулан гэрээ байгуулаад байна.

Энэ ажил хэрэгжсэнээр өнөөдрийн байдлаар өмнөө тавьсан хөрс тээврийн зорилтоо бүрэн биелүүлж цаашид хөрсний хоцрогдлыг богино хугацаанд бүрэн арилгах тооцоолол гарч байна.

8. 2015-2016оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан 70%-тай гүйцэтгэсэн байна. Компанийн хэмжээнд ТББК 0.63%, ТАК 0,61% гарсан.

Өвлийн бэлтгэл ажлын гүйцэтгэл нь технологийн автомашины коробка болон явах ангийн их засвар хийгдээгүй /1 коробка, 1 редуктор, 1 явах анги/, ЭКГ-10 цахилгаан экскаватор, хөрсний автосамосвал 130тн 3ш, 40тн 3ш, дугуйт түрэгч 7,5м<sup>3</sup>, паз автобус, хөдөлгүүр засварын багаж хэрэгсэл нийлүүлэх, ЭШ-25/90 алхагч экскаваторын удирдлагын систем солих ажил, барилга байгууламжаас орон сууцны 14-р байрны дээврийн урсгал засвар, анкар зөөж угсрах засварын ажил хийгдээгүй шалтгаанаас болсон. Ирэх онд Үйлдвэрлэлийн бүрэн хяналтын ERP систем нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн зардлыг 5-8%-аар бууруулах, мөн хөдөлгүүр, трансмисс, цахилгаан хөдөлгүүр, генераторуудын засварыг өөрсдөө хийж өртөг бууруулах, зардал хэмнэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

#### **4. Худалдан авах үйл ажиллагааны талаар:**

Тус компанийн 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөр нийт 93 нэр төрлийн 84,468,143.7 мян.төгрөг тусгагдсанаас гүйцэтгэлээр 46,664,015,110 мян.төгрөг худалдан авалт хийгдэж худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт 55,2 хувьтай байлаа.

Түүний дотор өөрийн хөрөнгөөр худалдан авахаар 26,090,437.2 мян төгрөг төлөвлөсөн худалдан авалтын биелэлт 92,0 хувь бусад эх үүсвэрээр худалдан авахаар төлөвлөсөн худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт 7,17 хувь байлаа.

Нийт худалдан авалтын 34 хувь буюу 15,975,508,799 мян.төг нь нээлттэй тендер шалгаруулалтаар 56 хувь буюу 26,131,848,462 нь хуулийн дагуу харьцуулалтын аргаар 10 хувь нь шууд худалдан авалтын аргаар хийгдсэн байна.

Уурхайд хэрэглэгддэг сэлбэг материалын дийлэнх хэсгийн нь үнийн дүн нь 50 саяас бага, багцлах боломжгүй олон төрлийнх сэлбэг материал эзэлдэг тул харьцуулалтын болон шууд худалдан авалтын аргаар хийгдэх худалдан авалтын хэмжээ өндөр байдаг.

Төсөвт өртөг бага байгаагаас шалтгаалан компаниуд тендерт оролцохоос татгалздаг үүнээс шалтгаалан нь хуулийн дагуу харьцуулалтын тендер шалгаруулалт арга хэрэглэхөөс өөр аргагүй байдалд хүрдэг. Ийм тохиолдол 2015 онд 7 удаа гарч 4 505 404,2 мянган төгрөгийн бараа материалыг харьцуулалтын аргаар авсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын дүн нь төсөвт өртөгөөсөө 3.733.086.3 мян.төгрөгөөр бага байсан тул энэ хэмжээгээр мөнгөн хөрөнгийн болон зардлын хэмнэлт үүссэн байна.





"ШИВЭЭ ОВОО" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ О ОТГОНБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016. 04.12 № 3/621  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Шивээ Овоо" ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

"Шивээ Овоо" ХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

"Шивээ Овоо" ХК-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

- Тус компани нь уурхайн талбайг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлагыг хуулиар хүлээсэн бөгөөд НББОУС 37 *Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө* стандартын дагуу өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зарлагын тооцооллыг тооцоолоогүйгээс санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох боломжгүй байна.
- Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалыг үндэслэн 2009 онд үндсэн хөрөнгө түүхэн өртгөөр санхүүгийн тайланд тусгагдаж бодит үнэ цэнэ нь дансны үнээс ихээхэн ялгаатай болсон.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2016\0412SAG3.Docx

078621

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг болно гэдэгт итгэлтэй байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол "Шивээ Овоо" ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С. ЭНХЗАЯА



## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх үлдэгдэл		Аудитын залруулга	(төгрөгөөр)
	01-р сарын 01	12-р сарын 31		Аудитлагдсан үлдэгдэл 12-р сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,121,415,638.00	2,043,196,834.20	-	2,043,196,834.20
Дансны авлага	4,230,011,608.29	3,258,868,812.80	(127,165,849.95)	3,131,702,962.85
Татвар, НДШ -ийн авлага	32,948,296.04	370,012,934.44	(17,452,892.30)	352,560,042.14
Бусад авлага	280,846,311.42	280,846,310.73	(280,846,310.73)	-
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-
Бараа материал	11,117,045,527.43	11,675,060,668.99	(822,522,896.42)	10,852,537,772.57
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	971,785,388.49	1,816,520,380.10	(43,175,031.92)	1,773,345,348.18
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>17,754,052,769.67</b>	<b>19,444,505,941.26</b>	<b>(1,291,162,981.32)</b>	<b>18,153,342,959.94</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө	59,351,841,807.72	57,273,813,863.71	-	57,273,813,863.71
Хөрс хуулалтын хөрөнгө	13,777,532,290.00	21,082,229,544.57	-	21,082,229,544.57
Урт хугацаат хөрөнгө оруулалт	530,131,395.36	-	-	-
Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	(552,975,042.00)	(1,480,803,734.42)	-	(1,480,803,734.42)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	530,131,395.36	-	530,131,395.36
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,288,134,203.00	2,991,112,937.00	-	2,991,112,937.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>74,394,664,654.08</b>	<b>80,396,484,006.22</b>	<b>-</b>	<b>80,396,484,006.22</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>92,148,717,423.75</b>	<b>99,840,989,947.48</b>	<b>(1,291,162,981.32)</b>	<b>98,549,826,966.16</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
Дансны өглөг	9,631,875,067.01	16,964,741,010.42	(414,985,731.89)	16,549,755,278.53
Цалингийн өглөг	217,861,063.79	245,259,488.15	-	245,259,488.15
Татвар, ЭМД, НДШ -ийн өр	1,677,064,076.39	1,465,158,557.99	(16,136,371.83)	1,449,022,186.16
Богино хугацаат зээл	1,899,679,165.00	2,092,767,503.55	123,899,162.95	2,216,666,666.50
Урьдчилж орсон орлого	11,429,134.81	99,331.81	-	99,331.81
Хүүний өглөг	247,526,487.00	702,374,038.69	(277,087,807.00)	425,286,231.69
Засгийн газрын дэмжлэг	3,530,703,470.00	3,111,820,512.00	-	3,111,820,512.00
Санхүүгийн түрээсийн өглөг	1,573,628,275.00	3,743,958,500.60	(1,519,028,275.00)	2,224,930,225.60
Бусад богино хугацаат өр төлбөр	20,071,592,469.00	23,215,037,879.74	(51,791,536.00)	23,163,246,343.74
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>38,861,359,208.00</b>	<b>51,541,216,822.95</b>	<b>(2,155,130,558.77)</b>	<b>49,386,086,264.18</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
Урт хугацаат зээл	20,735,584,241.00	18,671,920,262.42	-	18,671,920,262.42
Засгийн газрын дэмжлэг	25,950,110,916.00	22,838,290,403.69	-	22,838,290,403.69
Ажилчдын тэтгэвэрийн сан	986,392,358.00	1,056,906,953.00	-	1,056,906,953.00
Санхүүгийн түрээсийн өглөг	2,095,006,840.00	41,378,565.13	1,519,028,275.00	1,560,406,840.13
Хойшлогдсон татварын өр	194,175,477.00	358,564,643.00	-	358,564,643.00
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>49,961,269,832.00</b>	<b>42,967,060,827.24</b>	<b>1,519,028,275.00</b>	<b>44,486,089,102.24</b>
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>88,822,629,040.00</b>	<b>94,508,277,650.19</b>	<b>(636,102,283.77)</b>	<b>93,872,175,366.42</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>				
Өмч : -Төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00	-	1,207,710,000.00
-Хувийн	-	-	-	-
-Хувьцаат	134,190,000.00	134,190,000.00	-	134,190,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	596,786,316.24	(596,786,316.24)	-
Хуримтлагдсан ашиг	1,984,188,383.75	3,394,025,981.05	(58,274,381.31)	3,335,751,599.74
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,326,088,383.75</b>	<b>5,332,712,297.29</b>	<b>(655,060,697.55)</b>	<b>4,677,651,599.74</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>92,148,717,423.75</b>	<b>99,840,989,947.48</b>	<b>(1,291,162,981.32)</b>	<b>98,549,826,966.16</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх дүн		Аудитын залруулга	(төгрөгөөр)
	2014 онд	2015 онд		Аудитлагдсан дүн
				2015 онд
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)</b>	<b>36,163,584,468.00</b>	<b>37,855,404,279.22</b>	<b>(95,697,114.37)</b>	<b>37,759,707,164.85</b>
Борлуулалтын өртөг	29,027,118,902.00	31,644,859,048.79	617,372,182.21	32,262,231,231.00
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	7,136,465,566.00	6,210,545,230.43	(713,069,296.58)	5,497,475,933.85
<b>Бусад орлого</b>	<b>4,456,853,564.81</b>	<b>3,992,480,911.89</b>	<b>10,758,965.11</b>	<b>4,003,239,877.00</b>
	<b>4,456,853,564.81</b>	<b>3,992,480,911.89</b>	<b>10,758,965.11</b>	<b>4,003,239,877.00</b>
Борлуулалт маркетингийн зардал	-	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	2,099,793,692.70	1,663,622,008.78	-	1,663,622,008.78
Санхүүгийн зардал	5,954,487,393.00	164,389,100.00	-	164,389,100.00
Хүүгийн зардал	-	991,818,222.80	-	991,818,222.80
Бусад зардал	1,490,651,704.46	5,554,665,500.00	476,122,865.36	6,030,788,365.36
	<b>9,544,932,790.16</b>	<b>8,374,494,831.58</b>	<b>476,122,865.36</b>	<b>8,850,617,696.94</b>
<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>2,048,386,340.65</b>	<b>1,828,531,310.74</b>	<b>(1,178,433,196.83)</b>	<b>650,098,113.91</b>
Орлогын татварын зардал	158,970,357.00	137,869,747.27	(72,859,935.88)	65,009,811.39
<b>ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>1,889,415,983.65</b>	<b>1,690,661,563.47</b>	<b>(1,105,573,260.95)</b>	<b>585,088,302.52</b>
Хойшлогдсон ОАТ-ын зардал	131,913,441.00	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	<b>1,757,502,542.65</b>	<b>1,690,661,563.47</b>	<b>(1,105,573,260.95)</b>	<b>585,088,302.52</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
<b>ОРЛОГЫН НИЙТ ДҮН</b>	<b>1,757,502,542.65</b>	<b>1,690,661,563.47</b>	<b>(1,105,573,260.95)</b>	<b>585,088,302.52</b>
<b>НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)</b>				



## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Түншийн тайлангаарх дүн		(төгрөгөөр) Аудитлагдсан дүн
	2014 онд	2015 онд	2015 онд
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>27,953,636,494.38</b>	<b>41,616,764,100.00</b>	<b>41,616,764,100.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	27,282,232,093.00	40,943,880,700.00	40,943,880,700.00
Туслах үйл ажиллагаанаас олсон орлого	566,563,833.38	568,042,800.00	568,042,800.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	104,840,568.00	104,840,600.00	104,840,600.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>33,663,214,994.81</b>	<b>39,390,528,503.80</b>	<b>39,390,528,503.80</b>
Ажиллагсадад төлсөн	6,556,945,226.08	7,708,981,100.00	7,708,981,100.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,105,000,000.00	1,635,302,000.00	1,635,302,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	16,562,932,310.00	16,562,932,300.00	16,562,932,300.00
Ашиглалтын зардалд төлсөн	5,870,344,480.34	8,566,264,900.00	8,566,264,900.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	246,587,640.57	339,328,938.00	339,328,938.00
Хүүний төлбөрт төлсөн	254,224,477.13	392,230,400.00	392,230,400.00
Татварын байгууллагад төлсөн	2,089,915,853.00	3,183,172,000.00	3,183,172,000.00
Бусад мөнгөн зарлага	977,265,007.69	1,002,316,865.80	1,002,316,865.80
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,709,578,500.43)</b>	<b>2,226,235,596.20</b>	<b>2,226,235,596.20</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>1,152,200.00</b>	<b>1,152,200.00</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		1,152,200.00	1,152,200.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>150,000,000.00</b>	<b>1,722,246,000.00</b>	<b>1,722,246,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн		1,572,246,000.00	1,572,246,000.00
Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн	150,000,000.00	150,000,000.00	150,000,000.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(150,000,000.00)</b>	<b>(1,721,093,800.00)</b>	<b>(1,721,093,800.00)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,454,000,000.00</b>	<b>5,459,542,200.00</b>	<b>5,459,542,200.00</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,454,000,000.00	5,454,000,000.00	5,454,000,000.00
Төрөл бүрийн хандив		5,300,000.00	5,300,000.00
Валютын ханшийн зөрүү		242,200.00	242,200.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,689,345,534.08</b>	<b>5,042,902,800.00</b>	<b>5,042,902,800.00</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,645,192,172.00	2,229,811,600.00	2,229,811,600.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	44,142,127.90	2,807,780,000.00	2,807,780,000.00
Төрөл бүрийн хандив	11,234.18		
Валютын ханшийн зөрүү		5,311,200.00	5,311,200.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,764,654,465.92</b>	<b>416,639,400.00</b>	<b>416,639,400.00</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(2,094,924,034.51)</b>	<b>921,781,196.20</b>	<b>921,781,196.20</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,216,339,672.51	1,121,415,638.00	1,121,415,638.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,121,415,638.00	2,043,196,834.20	2,043,196,834.20

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2015 оны 01 -р сарын 01 -ий үлдэгдэл</b>	<b>1,341,900,000.00</b>	<b>1,984,188,383.75</b>	<b>3,326,088,383.75</b>
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		766,474,913.47	<b>766,474,913.47</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,341,900,000.00</b>	<b>1,984,188,383.75</b>	<b>4,092,563,297.22</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		585,088,302.52	585,088,302.52
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ногдол ашиг			-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
<b>2015 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл</b>	<b>1,341,900,000.00</b>	<b>3,335,751,614.17</b>	<b>4,677,651,599.74</b>

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
АУДИТЫН ХОРОО**

---

2016 оны 04-р сарын 11-ны өдөр

Дугаар 2016/01

**2015 оны жилийн эцсийн зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн  
биелэлтэд өгөх дүгнэлт**

“Шивээ-Овоо” хувьцаат компани нь 2015 оны санхүүгийн тайлан тэнцлийг 12 дугаар сарын 31–нээр тасалбар болгон үйл ажиллагааны үр дүн санхүүгийн байдлыг хуулийн хугацаанд нь гарган Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гаргасан тухайгаа гүйцэтгэх удирдлага баталсан байна. Олон улсын хараат бус хөндлөнгийн Аудитын байгууллага “Эрнест Янг Монголиа” ХХК-нь “Шивээ-Овоо” ХК-ийн 2013-2015 оны санхүүгийн тайлан тэнцэлд аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргаж ОУНББ-ын стандартад нийцүүлэн томоохон өөрчлөлтүүдийг хийсэн байна.

**Нэг: Үндсэн үзүүлэлтийн талаар**

“Шивээ-Овоо” хувьцаат компани 2015 оны гүйцэтгэлээр 7,042,9 мянган м куб хөрс хуулж 1,736,5 мян. тонн нүүрс олборлон 1,817,8 мян. тонн нүүрс борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөөг 82,1 хувь, нүүрс олборлолтын төлөвлөгөөг 75,0 хувь, борлуулалтын төлөвлөгөөг 78,8 хувиар биелүүлжээ.

**Нүүрс борлуулалтын орлогын талаар**

2015 онд 1.817.8 мян. тонн нүүрс борлуулж дийлэнхийг “ДЦС-4” ХК-д нийлүүлжээ. 2015 онд нүүрс хэрэглэх шинэ харилцагч бараг нэмэгдээгүй байна.

Нүүрс борлуулалтын орлого 37,860.6 сая төг болж, төлөвлөгөө 21,4 хувь буюу 495.5 сая төгрөгөөр тасарсан байна, Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.7 хувь буюу 195.9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. 2015 онд нэг тонн нүүрсийг дунджаар 20,828.2 төгрөгөөр борлуулсан байна.

**Хоёр: Санхүүгийн үйл ажиллагааны талаар**

**Үйл ажиллагааны үр дүнгийн талаар:** 2015 онд төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан бизнес төлөвлөгөөгөөр нийт 49,225,8 сая төгрөгийн борлуулалт хийж 55,897,5 сая төгрөгийн зардал гарган 6.671.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгдсөн.

2015 онд уурхайн үндсэн үйл ажиллагаанаас 37.759.7 сая төгрөгийн орлого олж 33.925.9 сая төгрөгийн зардал гарган 3.833.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанаас 4003.2 сая төгрөгийн орлого олж, 7186.9 сая төгрөгийн зардал гарган 3183.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Компани нийт дүнгээр 650.1 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна.

**Үйлдвэрлэлийн өртөг зардлын талаар** 2015 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нүүрс олборлолтын нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 28,7 хувь буюу 15,069,3 сая төгрөгөөр буурсан байна. Мөн өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,2 хувиар буюу 449.0 сая төгрөгөөр буурчээ.

2015 онд нэг тонн нүүрсийг 21,551,0 төгрөгөөр олборлон 19,371.4 төгрөгөөр борлуулсан. Нүүрс борлуулалтын нэгж тутамд 1456.7 төгрөг нэмэгдсэн байна. Борлуулалтын нэгжийн үнэ дунджаар 2869.1 төгрөгөөр нэмэгдсэн тооцоо гарч байна.

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлуудаас 17 төрлийн зардал төлвөлснөөс хэмнэгдэж дүнгээрээ 15.236.7 сая төгрөг хэмнэсэн дүн гарч байна. Үндсэн хөрөнгийн элэгдэл, нөхөн сэргээлтийн зардал, бусад зардлууд 167.4 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ний төлөвлөгөөний биелэлт дөнгөж 10.5 хувийн биелэлттэй байна.

**Удирдлагын үйл ажиллагааны зардлын талаар:** Удирдлагын үйл ажиллагааны зардалд 2,342,023.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,663,622.0100 сая төгрөг болж 29,0 хувиар хэмнэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.4 хувь буурчээ.

**Авлага, өглөгийн талаар:** Нийт эргэлтийн хөрөнгийн 16.7 хувийг авлага эзэлж байна. Өнгөрсөн 2014 оны эцэст авлага 7,650,502,1 м.төг байсан бол тайлант оны эцэст 3,909,728,1 мян. төг болж 3,740,774,0 сая төгрөгөөр буурчээ.. Нийт 94,5 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаагаас урт хугацаат өр төлбөр 42.9 тэрбум, богино хугацаат өр төлбөр 49,3 тэрбум төгрөгийн өглөгтэй байна. Эргэлтийн хөрөнгийн 23,2%-ийг авлага эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрт дансны өглөг 16,9 тэрбум, цалингийн өглөг 245,2 сая, татварын өглөг 803.9 сая, НДШ -ийн өглөгт 661,2 сая, банкны богино хугацаат зээлийн өглөг 2,092.7 сая төгрөг хүүний өглөг 702,3 сая төгрөг нөөц өр 3,1 тэрбум төгрөг бусад богино хугацаат өр төлбөр 23,2 тэрбум төгрөг тус тус эзэлж байна.

#### **ДҮГНЭЛТ, САНАЛ:**

“Шивээ-Овоо” хувьцаат компани 2015 оны үндсэн үзүүлэлт болох хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө тасарсан. Татвар төлөхийн өмнөх ашиг 650,0 сая төгрөг гарсан байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үндсэн зардлууд хэмнэгдсэн, хөрс хуулалт, олборлолт, борлуулалтын төлөвлөгөө тасарсан нь зардал хэмнэгдэх нэг нөхцөл болжээ. Мөн хараат бус хөндлөнгийн Аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжөөр санхүүгийн тайлан тэнцэлд тухайн жилийн хөрс хуулалт, нүүрс олборлолтыг блокын өртөгийн аргаар тооцож, нүүрс олборлолт хийгдээгүй хөрс хуулалтын зардлыг “Хөрс хуулалтын хойшлогдох хөрөнгө” болгон бүртгэх, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдсэн элэгдлийн зардлыг буцааж өөрчлөлт оруулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хэрэглэгч ДЦС-4 ХК болон бусад хэрэглэгчид нүүрсний үнээ цаг хугацаанд нь төлөхгүй байсан зэрэг шалтгаанаас компаний санхүү, төлбөрийн чадвар хүндэрч, төлөвлөсөн хөрөнгө оруулалт, ТЗБАХ-нд тусгагдсан их болон агергат засвар, тоног төхөөрөмжүүдийн засвар, үйлчилгээг цаг хугацаанд нь хийж чадахгүй байгаа зэрэг нь зардал хэмнэгдэх нэг нөхцөл болж нөлөөлжээ. Энэхүү байдал нь уурхайн үндсэн машин техникийн хэвийн үйл ажиллагаанд цаашид сөргөөр нөлөөлж болзошгүй юм. 2015 оны ХО болон ТЗБАХ-ний төлөвлөгөөний биелэлт дөнгөж 10,5 хувь байгаа нь хөрөнгийн эх үүсвэр төлбөрийн чадвартай холбоотой байна.

Эрчим хүчний зориулалтаар борлуулж байгаа нүүрсийг олон жил өртөгөөс нь доогуур үнээр борлуулж байсан нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулахад ихээхэн хүндрэл учруулж байсныг цаашид анхаарах нь зүйтэй.

Нийт богино хугацаат өглөг 49,386,086.3 сая төгрөгт хүрсэн нь компанийн мөнгөн урсгалд муугаар нөлөөлж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, богино хугацаат өр төлбөрөө төлж чадахгүй байдалд орж санхүүгийн тогтвортой байдлыг бууруулж байна.

Хэдийгээр уурхайн тоног төхөөрөмжүүдийн насжилт өндөр, эвдрэл сааталтай ихтэй, санхүү төлбөрийн чадвар хүндрэлтэй байсан хэдий ч “Шивээ-Овоо” хувьцаат компанийн



гүйцэтгэх удирдлага 2015 оны өвлийн оргил ачаалыг амжилттай давж хэрэглэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн.

Компанийн 2015 оны жилийн эцсийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшингийн биелэлт, санхүүгийн тайлан тэнцлийн дүнд дүгнэлт хийж, үйлдвэрлэлийн бус зардлыг багасгах, богино хугацаат өр авлагын өндөр өсөлтийг бууруулах иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгвөл зохино.

---- АУДИТЫН ХОРОО ---

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

**2016.04.13**

**Улаанбаатар хот**

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 100 дугаар 2016 оны 68 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий нүүрсний уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг “Шивээ Овоо” ХК-ийн эзэмшлийн төрийн төлөөллийг хангах, компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний 90 хувийн төлөөллийг бүрдүүлэн ажиллах үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосон.

“Шивээ Овоо” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн байгуулагдаж Компанийн тухай хууль, компанийн дүрмийн хүрээнд компанийн сайн засаглалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2015 оны 05 дугаар сараас эхлэн нийт 11 удаа хуралдаж 35 тогтоол, 8 тэмдэглэл гаргаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 1 удаа зохион байгуулан “Шивээ Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирал, мэргэжилтэн албан хаагчдын мэдээллийг тогтмол сонсож тухай бүр нь шийдвэрлэж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөр нийт 37 асуудлыг хэлэлцэж 35 асуудлыг нь шийдвэрлэн 1/лаг шахах төхөөрөмж худалдан авах/ асуудлыг буцаасан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Шивээ Овоо” ХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, уурхайн үйл ажиллагааг сайжруулах, менежмент удирдлагын арга барилыг шинэчлэх, компанийн эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд анхаарч ирлээ. “Шивээ Овоо” ХК-ийн эдийн засаг, санхүүгийн байдлын сайжруулах зорилгоор компанид олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар үйл ажиллагааны болон санхүүгийн аудит хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон.

“Шивээ Овоо” ХК нь 2009-2015 оны хооронд алдагдалыг 11 тэрбум төгрөгөөс тогтмол бууруулж ажилласан бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК тус компанийн менежментийг хэрэгжүүлж эхэлсэн буюу 2013 онд 2,9 тэрбум төгрөгийн 2014 онд 4,9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2015 онд 650 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Шивээ Овоогийн хүрэн нүүрсний үнийг чөлөөлүүлэх, үнийг нэмэгдүүлэх талаар тогтмол анхааран Эрчим хүчний зохицуулах хороотой хамтарч ажилласаны үр дүнд Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 28 дугаар тогтоолоор нүүрсний үнийг 2000 төгрөгөөр нэмэгдүүлэн 23060 төгрөгт хүргэж нүүрс олборлолтын өртөг зардлыг тэнцүүлэх арга хэмжээ авлаа.

Мөн хувийн хэвшлийн “Шинэ Шивээ” ХХК-ийн хүрэн нүүрсний нөөц болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нөөцийг нэгтгэн 1,2 тэрбум нүүрсний нөөцтэй “Шивээ Энержи” ХХК-ийг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллаа. Ингэсэнээр Хятад улсын Стате Грид төрийн өмчит компанитай хамтран жилд 34 сая тонн нүүрс олборлон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг эхлүүлэх, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил эхлээд байна.

Нүүрс олборлолтын техник, технологийг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэлээр олон ажлыг хэрэгжүүлж ирсэн ба түүнчлэн Шивээ Овоогийн уурхайн техник технологийг 2020 он хүртэл шинэчлэх урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж баталуулаад байна.

Уурхайн өргөтгөлийн ажлын санхүүгийн эх үүсвэр бий болгох, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, компанийн засаглалын тэргүүн туршлага нэвтрүүлэх хүрээнд “Шивээ Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувийг 51 хувь хүртэл бууруулах замаар нэмэлт хувьцаа гаргах ажлын бэлтгэлийг хангаад байна. Энэхүү ажлын үр дүнд “Шивээ Овоо” ХК нь нийт 40 орчим тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөөүүлэх урьдчилсан тооцоотой байгаа болно.

**Аудитын хороо:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо нь 2015 онд дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Компанийн 2014 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн биелэлтэд дүгнэлт хийж зөвлөмж гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний тогтоол гаргуулж гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгүүллээ.

2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэлд дүгнэлт хийж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан. Компанийн 2015 эхний хагас жилийн хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалт тасарч байгааг анхаарч уурхайн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийг ханган биелүүлэх талаар авах хэмжээний чиглэлийг гаргаж өглөө.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу компанийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцтай танилцах, гүйцэтгэх удирдлагаас актлуулахаар ирүүлсэн тээврийн хэрэгсэлийг газар дээр нь үзэж дүгнэлт гаргах, өвлийн бэлтгэл хангахад зайлшгүй шаардлагатай гэж гүйцэтгэх удирдлагын үзэж байгаа 3,6 тэрбум төгрөгийн сэлбэг хэрэгсэлийн үндэслэлийг тогтоох ажлыг компанийн холбогдох албаны хүмүүс, анхан шатны нэгжүүдийн ажил байдалтай газар дээр нь танилцаж холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан. Төлөөлөн удирдах зөвлөл шаардлагатай авах арга хэмжээг авч асуудлыг шийдэж өгсөн болно.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 21-нээс 2015 оны 11 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг үйлдвэрийн анхан шатны нэгжид хэрхэн зохион байгуулж байгааг танилцаж дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргаж шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, оршиж байгаа дутагдал, доголдлыг арилгах үүргийг гүйцэтгэх удирдлагад өгсөн.

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ТОГТООЛЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2016.03.10-ны өдөр

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагаатай холбогдсон тогтоолуудын хэрэгжилт агуулгыг дараах байдлаар дэлгэрэнгүй үзүүлэв.

12	2015.05.21	Жилд 2,0 сая тонн нүүрс борлуулахад өөрсдийн хувь нэмрээ орлуулж ажилласан 439 ажилтанд тус бүр 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосугай.	-468,521,021 төлөвлөснөөс “Шивээ-Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2015.08.31 өдрийн Б/307 тоот тогтоолоор 458,488,112 төгрөгийг олгосон.	100%
13	2015.05.21	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн бүтэц ажилтануудын орон тоог 1 дүгээр хавсралтын дагуу нэмэлт өөрчлөлт оруулсугай.</li> <li>Компанийн ажилтануудын цалингийн зардлыг 2015 онд баталсан төсөвт өртөгөөс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>2015.05.21-ний ТУЗ-ын тогтоолыг үндэслэн мөрдлөг болгож 2015 онд нийт 595 –н үндсэн болон түр гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар төлөвлөснөөс 547 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.</li> <li>Компанийн цалингийн зардлыг төсөвт өртөгт нь бариулж нийт ажилтан албан хаагчдын цалинг 10 хувиар нэмсэн.</li> </ul>	100%
14	2015.05.21	Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай	Компанийн авто жингээр худалдан борлуулах нүүрсний үнийг 30118 төгрөг, төмөр замаар дамжуулан бусад хэрэглэгчдэд худалдан борлуулах нүүрсний үнийг 26642 төгрөг болгож нэмэгдүүлээ.	100%
17	2015.07.01	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн хэвийн үйл ажиллагааг хангах, өр төлбөрийг барагдуулах зорилгоор 2,5 тэрбум төгрөгийн зээлийг борлуулалтын орлого барьцаалан 6 сарын хугацаатай сарын 1,7 хувийн хүүтэй авахыг ГЗ-д зөвшөөрсүгэй.</li> </ul>	Хас банкнаас 2015 оны 7 сарын 16-ны өдөр 1 тэрбум төг Голомт банкнаас 2015 оны 10 сарын 7-ны өдөр 1,5 тэрбум төгрөг гэсэн байдлаар Зээлийг 2 хуваан авч өр төлбөрөө төлөхөд зарцуулсан. Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн явагдаж байна.	75%
18	2015.07.01	Компанид олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар Аудит хийлгэх бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулж ТУЗ-д танилцуулах	Олон Улсын Эрнест Яанг анд Монголиа Аудит ХХК нь 2013, 2014, 2015 оны 6 сар хүртэл аудит хийж аудитын тайланг холбогдох байгууллагад хүргүүлж Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн хугацаанд тайлангийн засварыг хамрууллаа.	100%

19	2015.07.01	ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодын ажиллах журамьг батлав.	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Хороодын журмыг баталж уг журмын дагуу Аудитын хороо гурван удаа хуралдаж дүгнэлтээ Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлээд байна.	100%
20	2015.07.01	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн өр авлага барагдуулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ТУЗ-д тогтмол танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.</li> <li>Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн хагас жилийн тайлан, өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг ТУЗ-н 2015 оны 7-р сарын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэх, арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай</li> </ul>	<p>Гүйцэтгэх захирлын тушаал гарган комисс байгуулж ажиллуулсан. Томоохон авлагуудаас Бор-өндөрийн УБҮ-н авлагг 476,0 сая төгрөгөөр бууруулж бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулсан. Чандмань илч ХХК-аас авах авлагаа 90,0 сая төгрөгөөр ДЦС-4 ТӨХК-аас авах авлагаа 600,0 сая төгрөгөөр тус тус бууруулсан:</p> <p>Мөн 32 ажилтаны 10,6 сая төгрөгийн өрийг 1176,6 сая төгрөгийн авлагыг барагдуулаад байна.</p> <p>Тус 1,1 тэрбум төгрөгийн бусад харилцагчдад өр төлбөрөө бууруулахад зарцуулсан болно.</p> <p><u>Дэлгэрэнгүйг Е.Нябо С.Одбаяр</u></p>	80%
21	2015.09.03	<ul style="list-style-type: none"> <li>Хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын тасалдалыг нөхөх замаар 2015 оны зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр нь ханган биелүүлэхэд чиглэгдсэн арга замуудыг эрэлхийлж, шат дараалсан арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх</li> <li>2015 оны эхний хагасын санхүүгийн тайлан тэнцлийн дүнд санхүү эдийн засгийн алба эдийн засгийн шинжилгээ хийж, үр ашгийг дээшлүүлэх талаар авах арга хэмжээг төлөвлөж оршиж байгаа дутагдлыг арилгаж ажиллах,</li> <li>Авлага барагдуулах талаар бүтээлч ажил зориуд зохион байгуулж, ажил хариуцсан ажилтануудын ажлын үр дүнтэй холбож дүгнэж, ажлын явцад хяналт тавьж төлбөрийн чадварыг дээшлүүлэх, өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх</li> <li>ДЦС-4 ХХК-тай өмнөх жилүүдэд үүссэн 2,7 тэрбум төгрөгийн авлагыг “Шивээ–Овоо” ХК-ийн цахилгаан эрчим хүчний хэрэглээнд суутган тооцох асуудлыг төрийн эрх бүхий байгууллага болон шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх</li> </ul>	<p>1.Үндсэн үзүүлэлт зорилтот түвшингийн биелэлтийг хангуулах чиглэлээр – 100%</p> <ul style="list-style-type: none"> <li>Уулын 2-р хэсгийн 50 га талбайд геологийн нарийвчилсан хайгуул хийлгэж, нөөцийг нарийвчилан тогтоолгосон / “Монконвер транспорт” ХХК – 43 сая.төг /</li> <li>Уулын 2-р хэсэгт экскаватор №04-г оруулж 500 мян.м3 хөрс хуулсан.</li> <li>Гадны туслан гүйцэтгэгч компаниар тээвэртэй хөрс хуулах тендерийг зарлаж 300 мян.м3 хөрс тээвэрлэх гэрээг байгуулсан./Ажил амжилттай дууссанаар шилжих нөөц 400 мян.тн болох боломжтой./</li> <li>ЭШ 25/90 алхагч экскаваторыг баруун жигүүрт ажиллуулж 200 мян.тн нүүрс нээсэн.</li> </ul>	70%

		<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний зориулалтын нүүрсний чийг үнийг өөрийн өртөгт нь хүргэж нэмэгдүүлэх саналыг боловсруулж холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх</li> <li>• 2016 оны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулах арга хэмжээ авах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд урьдчилан төслийг хүргүүлэх арга хэмжээ авах,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ЭШ 11/70 , ЭЖГ-5А №04 экскаваторуудыг зүүн жигүүрт ажиллуулан 250 мян.тн нүүрс нээсэн.</li> </ul> <p>2. Эдийн засгийн шинжилгээ хийж, дүгнэлт гарган зээлээр хийх худалдан авалтыг нэмэгдүүлэхгүй байх, Ажилчидын өр авлагыг бууруулах,борлуултанд эзлэх жижиг хэрэглэгчдийн тоо хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна. – 100%</p> <p>3. Энэ заалтыг биелэлтийг өмнөх 20-р тогтоолын биелэлтээс харна уу. Хариуцсан ажилтаны ажлын үр дүнтэй холбох механизм бий болгоогүй. – 75%</p> <p>4.Энэ чиглэлээр Үндэсний аудитын газарт санал хүргүүлж зөвлөмжинд нь тусгуулан холбогдох дээд байгууллагуудад нь танилцуулахаар хүргүүлээд байна. 75%</p> <p>5. Ашигт малтмалын газрын лаборатортой гэрээ байгуулан илчлэгийн стандартыг бууруулах ажлыг зохион байгуулж эхлээд байна. – 75%</p> <p>6. Энэ заалт хэрэгжиж амжаагүй байна.</p>	
22	2015.09.03	Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор хавсралтанд заасан сэлбэг хэрэгслийг худалдан авахыг дэмжсүгэй	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор тухайн сэлбэг хэрэгслийг худалдаж авахыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсөн.	100%
23	2015.09.03	Өвөлжилтийн бэлтгэл ажилд онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хавсралтанд заасан сэлбэг хэрэгслийг харьцуулалтын аргаар худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг зөвшөөрсүгэй	Санхүүгийн боломжгүй хойшлогдож байна. 2016 оны бизнес төлөвлөгөөнд уг сэлбэг хэрэгслийг худалдан авахаар тусгасан болно.	0%
24	2015.09.15	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулж, алданги торгууль төлөхөөс сэргийлэх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор 1,5 тэрбум төгрөгийн зээл авах эрхийг ГЗ-д зөвшөөрсүгэй.</li> </ul>	Хас банкнаас 1,5 тэрбум төгрөгийн зээл авч үйл ажиллагаанд зарцуулсан.	75%
25	2015.09.29	<ul style="list-style-type: none"> <li>• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 11-р сарын 4-ны өдрийн 14 цагт Монгол улс, Улаанбаатар хот, “Шивээ-Овоо”ХК-н төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдуулсугай.</li> </ul>	Тогтоолоор батлагдсан “Хурал зохион байгуулах комисс, “Хурлын тооллогын комисс”-ын гишүүд чиг үүргийн дагуу хурлыг амжилттай зохион байгуулсан.	100%

		•		
26	2015.09.29	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хавсралтад заасан 6 ш 2,122,865.5 төг-ийн анхны үнэ бүхий техник тоног төхөөрөмжийг акталж, данснаас хасах, зарим эд ангийг үнэлж ашиглах саналыг зүйтэй гэж дүгнэсүгэй.</li> <li>Энэхүү тогтоолыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-р хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг ГЗ-д даалгасугай.</li> </ul>	Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах асуудалд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ажлын хэсгийн гишүүдийн дүгнэлтийг үндэслэн 11-р сарын 13-нд компанийн ТУЗ-өөр дахин хэлэлцүүлж шийдвэрлэсэн.	100%
27	2015.09.29	<ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын төрийн өмчийн хорооноос зохион байгуулж буй “Шивээ-Овоо”ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгох үйл ажиллагаанд Андеррайтер-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани шалгаруулах тендер шалгаруулалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг ГЗ-д даалгасугай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Шивээ-Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2015.10.23-ны өдрийн А/102 тушаалаар Андеррайтер зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулах “Эрдэнэс Монгол” ХХК болон “Шивээ-Овоо”ХК, Иргэдийн төлөөлөл гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны даргаар СЭЗХ-ийн дарга Д.Батмөнх ажиллаж байна.</li> <li>Үнэлгээний хороо нь техникийн тодорхойлолтоо боловсруулан 3/11-ны байдлаар компаниудаас ирүүлсэн техникийн саналыг задлаад байна.</li> </ul>	50%
28	2015.09.29	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, ТУЗ-р явц үр дүнг батлуулахыг ГЗ-д даалгасугай.</li> </ul>	“Шивээ-Овоо”ХК-ийн гүйцэтгэх захирлын 2015.10.07-ны өдрийн А/98 тушаалаар дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг ТАЭДЗахирал Халиунаар ахлуулан 12-р сарын 1-ны өдөр 33-р хэлэлцүүлэн батлуулахыг үүрэг болгосон. Ажлын хэсэг чиглэл, чиглэлийн дагуу Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаад байна.	100%
29	2015.11.27	Сэрээт өргөгч худалдан авах зөвшөөрөл олгох тухай	Энгийн найрлагат тэсрэх бодисын үйлдвэрлэлд шаардлагатай сэрээт өргөгч худалдан авах эх үүсвэрийг 60 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 80 сая төгрөгөөр худалдан авах зөвшөөрөлийг Гүйцэтгэх захиралд олгосон.	100
30	2015.11.27	Сэлбэг хэрэгсэл худалдан авах тухай	Нийт 3,073 тэрбум төгрөгийг сэлбэг хэрэгсэл худалдан авахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн боловч хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан дээрх худалдан авалтыг хийгээгүй бөгөөд 2016 оны төсөвт дахин суулгасан.	50

31	2015.11.27	Эд хөрөнгө актлах тухай	“Шивээ Овоо” ХК-ийн Аудитын хорооны дүгнэлт болон Эрдэнэс Монгол ХХК-ийн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,1 тэрбум төгрөгийн 6 ширхэг тоног төхөөрөмжийг акталсан.	100
32	2015.11.27	Гидрийн шингэн худалдан авах зөвшөөрөл олгох тухай	ЭШ25/90 экскаворт Эрдэнэс Монгол ХХК болон Шивээ овоо компанийн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн гидрын шингэн худалдаж авах зөвшөөрлийг олголоо.	100
33	2015.11.27	Хөнгөлөлттэй үнээр нүүрс олгох тухай	Говь сүмбэр аймгийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийт 150 тонн нүүрсийг нийгмийн хариуцлагын хүрээнд ЭХЗХ-ны нүүрсний тарифаар олголоо.	100
34	2015.11.27	Цалин урамшууллын хорооны даргыг томилох тухай	Цалин урамшууллын хорооны даргаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьцааны төлөөлөгч Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ж.Төмөрпүрэвийг томиллоо.	100
35	2015.11.27	Шатахуун худалдан авах эрх олгох тухай	Шатахууны үнийн өсөлттэй холбогдуулан 1л дизел шатахууны үнийг 1650 төгрөгөөс дээшгүй үнээр худалдаж авах эрхийг Гүйцэтгэх захиралд олгож нийлүүлэгч компаниудтай энэ дагуу гэрээ байгуулсан болно.	100
Нийт биелэлтийн дундаж хувь				79%



**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны зардлын гүйцэтгэл  
2016 оны зардлын төсөв**

Дд.	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2015 оны		биелэлт	2016 оны
			төлөвлөгөө	хбгүйцэтгэл	%	төлөвлөгөө
1	Цалин хөлс НДШ	м.төг	44,205.6	51,836.4	1.17	63,867.6
2	Унааны зардал	м.төг	1,100.0	560.0	0.51	1,100.0
3	Хоолны зардал	м.төг	600.0	263.6	0.44	600.0
4	Томилолт	м.төг	192.0	640.0	3.33	700.0
5	Сургалт	м.төг	1,500.0	300.0	0.20	500.0
6	Бичиг хэрэг	м.төг	1,000.0	623.5	0.62	1,000.0
7	Хувьцаа эзэмшигчдийн хурал бүртгэл судалгаа	м.төг	10,300.0	4,150.0	0.40	5,000.0
8	Бусад	м.төг	1,500.0	6,309.8	4.21	20,000.0
	<b>Дүн</b>	<b>м.төг</b>	<b>60,397.6</b>	<b>64,683.3</b>	<b>1.07</b>	<b>92,767.6</b>
	Гишүүд		9	9		9
	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга		1	1		1

2015 оны гүйцэтгэлийн талаар

Нийт 60.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 64.4 сая төгрөг зарцуулж зардлыг 4 сая төгрөгөөр хэтрүүлсэн дүн мэдээ гарчээ. Хэтрүүлсэн шалтгаан:

1. 2015 оны төлөвлөлтийг хийхдээ ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, НДШ-ийг оруулалгүй төлөвлөсөн хэдий ч гүйцэтгэлдээ ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, НДШ-ийг оруулж тооцсон.
2. Өмнөх ТУЗ-ын гишүүн н.Даваасүрэнгийн 2014 оны НДШ-ийг 2015 онд нөхөн олгосноос (7.9 сая.төгрөг) зардлын хэтрэлт үүссэн.

Бусад зардлын тухайд (цалин, НДШ ороогүй) 2015 онд 16,2 сая төгрөг төлөвлөснөөс 12,8 сая төгрөг зарцуулж зардлыг 3,4 сая төгрөг буюу 21 хувь хэмнэсэн.

2016 оны төлөвлөгөөний талаар:

- ТУЗ-ийн хурлыг Улаабаатар хотод 10 удаа, компани дээр 2 удаа зохион байгуулна.
- ТУЗ нь дүрмийн дагуу 9 гишүүнтэй ажиллаж ТУЗ-ийн дарга сард 480,0, гишүүд 460,0 мянган төгрөгийн цалинтай байна. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг ТУЗ-ийн зардлын төсөвт суулгаж тооцсон ба 550,0 мянган төгрөгийн цалинтай байна. ТУЗ-ын дарга, гишүүдийн цалин нэмэгдүүлэх болсон нь салбарын бусад компанийн ТУЗ-ын дарга, гишүүдийн цалингийн доод хэмжээ, үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хэрэглээний үнэ тарифын өсөлт зэргийг харгалзан үзсэн болно.
- Бусад зардалд ТУЗ-ын 3 хорооны ажил, ТУЗ-ын гишүүдийн гадаад, дотоод томилолттой уялдан 20 сая төгрөгийг төсөвлөсөн.

---oOo---

## **ХУВЬЦААГ 51 ХУВЬ БАЙХ ХЭМЖЭЭНД НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 тоот тогтоолоор “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 330 тоот тогтоолоор “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ыг тус тус баталж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой тодорхой нэр бүхий 17 хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалтад “Шивээ Овоо” ХК багтсан бөгөөд төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжих замаар хөрөнгө төвлөрүүлж, уг төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх ажилд бүрэн зарцуулахаар болсон.

Өнөөдрийн байдлаар “Шивээ Овоо” ХК нь нийт 13,419,101 /арван гурван сая дөрвөн зуун арван есөн мянга нэг зуу нэг/ ширхэг энгийн хувьцаа бүхий хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд үүний 12,077,191 /арван хоёр сая далан долоон мянга нэг зуун ерэн нэг / ширхэг буюу 90% нь төрийн мэдэлд байдаг. УИХ болон Засгийн газрын дээрх тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд “Шивээ Овоо” ХК-ийн өнөөгийн нийт хувьцаанд эзэмшиж буй төрийн эзэмшлийн хувьцааг 51 хувь болгон бууруулахад 10,261,665 /арван сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран тав/ ширхэг хувьцааг нэмж гаргах шаардлагатай юм.

Компанийн хувьцааг нийтэд санал болгон болон нэмж гаргах, худалдахад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох эрх бүхий байгууллагын тогтоосон дүрэм, журмыг мөрдлөг болгодог бөгөөд эдгээр хууль тогтоомж, эрх зүйн актуудаар тодорхой шаардлага, шалгуурыг хангах, шат дараалсан ажиллагааг дэс дарааллын дагуу хэрэгжүүлэх ёстой. Үүний дагуу компанийн нэмж гаргах хувьцааг эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх, нийтэд санал болгон арилжаалахтай холбоотой үүсэх бүхий л харилцааг тодорхой гэрээний үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий андеррайтерын компани бүрэн хариуцаж ажиллах юм. Тиймээс компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд андеррайтерын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Компанийн хувьцааг нэмж гаргах, түүний тоог тогтоох эрх нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал бөгөөд Компанийн тухай хуулийн 34.2, 38.1 дэх хэсгүүдэд заасны дагуу хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргаж буй энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй байдаг. Ийнхүү нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн дийлэнх олонхийн санаал шийдвэрлэх ёстой.

---оОо---

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ  
нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцлийн дүн түүнд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт мэдээлэлээр 650.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байх тул компанийн үйл ажиллагааг хангалттай гэж тооцсугай.

2. “Шивээ овоо” ХК-ийн 2015 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг ..... сая төгрөг Үүнээс:

- А. Эргэлтийн хөрөнгийг ..... сая төгрөг
- Б. Биет үндсэн хөрөнгийг ..... сая төгрөгөөр
- В. Биет бус хөрөнгийг ..... сая төгрөгөөр
- Г. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг ..... сая төгрөгөөр
- Д. Урт хугацаат өр төлбөрийг ..... сая төгрөгөөр
- Е. Төрийн өмчийн дүнг ..... сая төгрөгөөр
- Ё. Эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг ..... сая төгрөгөөр
- Ж. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүнг ..... сая төгрөгөөр
- З. Хуримтлагдсан алдагдалыг ..... сая төгрөгөөр
- И. Богино хугацаат өр төлбөрийг ..... сая төгрөгөөр
- Й. Тайлант үеийн ашиг/ алдагдалыг..... сая төгрөгөөр тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх зүйлийг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК –ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг 92,767.6 сая төгрөгөөр тогтоож хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
тайланг батлах тухай

“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн Санхүүгийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтын дагуу 2016 оны 04 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын .... дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг 1 дүгээр хавсралтаар Хараат бус гишүүдийг 2 дугаар хавсралтаар 2016 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 04 сарын 28-ны  
Өдрийн .... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд  
хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил

Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 04 сарын 28-ны  
Өдрийн .... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн хараат бус гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил

---oOo---

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах  
давуу эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дугаар заалт, 38 дугаар зүйлийн 38.1 дугаар заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн нэмж зарласан нийт 10,261,665 /арван сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран тав/ ш хувьцааг дотоодын хөрөнгийн биржид гаргаж арилжаалахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хувьцааны зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгож шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД



**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 10.10.1 заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Шивээ Овоо” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж бүртгэлийн байгууллагаар баталгаажуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТАД ИРҮҮЛСЭН МАТЕРИАЛ**

№	Овог нэр	Мэргэжил
1	Ц.Цолмон	Эрх зүйч
2	Д.Дондов	Уул уурхайн инженер
3	Д.Батсүх	Үйлдвэрийн технологич
4	Д.Чилхаажав	Геологич, Эрх зүйч
5	Даваасүрэнгийн Баярсайхан	УУ-н ашиглалтын инженер
6	Г.Шаарийбуу	УУ-н ашиглалтын инженер
7	Ч.Батаа	Эдийн засагч
8	Л.Оюун	Эдийн засагч
9	О.Мөнхсайхан	Цахилгааны инженер
10	А.Батзориг	Уул уурхайн менежмент эдийн засагч
11	Ж.Баатарболд	Банк санхүүгийн удирдлага
12	Ц.Хурцбилэг	Социологич

Холбогдох материалтай Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Болдтой холбоо барин танилцана уу. Утас :95113131





ТАНИН МЭДЭХҮЙ  
ЦАГ БООРЛОГЧ

...Утмын Утгалттай оюу болсон сүүдэр жилийн дараа Ертөнцийн овоо, зууны цагийн  
хувиартай болох тухай хууль батлагдсан нь түүний хичээл зүтгэлтэй гажууд чиг үеийн  
байдалтай нэлтээжсэн байна...

МОНГОЛ ЦИРК 75

# "ТЭНГЭРИЙН ОХИН"



ЭЛЭРИН СӨРӨЛӨГЧИЙН

### Ж.СОЛОНГО

Хүний санаанд багтамгүй бүр  
үний бодит байдалд ирэхийн  
орлоо байдалтайтай. Тэрхэм  
1941 онд Уран биений тасарын  
сөрхөөнөө Утмын цирк хэллэх ага  
байжээ. 75 жилийн бэлгэе түгээх  
уралт үндэжээ. Огож, андийж, оргож  
дүгээж, унаж, дорножог лав аайлх  
милан ч тус сэлээх ирэхийн  
уралт зориулан олон айнаст  
ны ачаар Монголын циркийн урлаг  
дуулай хэвээр л байгаа. Сэлхэн л  
дээр урлах ч багтаах олон зууны  
циркийн таан мэлмээжээ али,  
төний чон хүртсэн билээ. Тэр бүнд  
дэлхийн циркийн урлахын дээд  
ажлын төгөөсөн жүжигчин ч бий.  
Монгол Улаад циркийн урлаг  
үргэж, дэлхийн 75 жилийн ойг тө-

хандуулан "Өндөр" оюу "Монгол  
цирк 75" буюу хэлж, түгээх төлөв-  
сөн дээд амжилтын эдийн төлөвлөг-  
лэх гэж байна.  
Эцэстэй үеийн бид Сэлхэн мэргэдийн  
ажлын, циркийн жүжгийн, урлаг  
сүлдэн Доржийн Шүрэнгэе олоно.  
Нэгэн дүгээ, алам заргай дийш  
чиэлээж асан боловч нь Д.Шүрэнгэе  
"Тэнгэрийн Охин" гэж  
хэрэглэж Монголын төндөгдөр дэлхийн  
циркийн урлахын дээд амжилтын  
эцэж, шийд байлгээх үеэж, агаарт  
сүлдэн үеэж хүртсэн түгээх 83 жилийн  
алам рекордын дагсан жүжигчин  
ойго ч үгүй.  
Д.Шүрэнгэе 1972 онд Ж.Гайнаа-  
базарын нэрлэжтэй Циркийн сөрөхд  
эцэж, дөрвөн жил суралд 1976 оны  
дундугаар сарын 1-нд Утмын циркийн  
жүжигчин болжээ.

Төгсгөл нь С3 нүүрт



"Залуусын золбоо" 1976 он. У.Элхвар,  
Н.Болдбаатар, Д.Шүрэнгэе нар

### ШИНЖЛЭХ УХААН

## Америкчууд Монголын үлэг гүрвэлүүдтэй танилцжээ

Америкийн Байгалийн түүхийн музейд өнгөрсөн даваа гаригт "Цагаар бийдэн дунд" нэртэй үзэгсэлэн нэлээт хийжээ. Тус музейн паэсопологиичи Монгол, Анхис, Румын, Хятадад очиж, нутгийн эдийн засагтэй хамтран судалсан дүнсэвэрийн олдвор, түүний зар-уурдугийг янд дэлгэсэн байна. Үзэгсэлэн Р.Барбод тэр-

Оларгогчид үлэг гүрвэлэйн аймгаг  
балах цагтаах өмөсөлэйлэг загвар.  
Цэрдийн талааны үед хамарч  
чиглэлтэй 1993 онд Олонсоос аймгаг  
Ухаангодоос аяг нэрлээж байжээ.

### СОНГОДОГ УРЛАГ

## Ө.Цэрэнчунт Маринскийд дууллаа

ОХУ-ын Буриад улсын дурд бүжгийн эрдмийн театрын гоцлоод дургчин Ө.Цэрэнчунт Маринский театрын тайлнаа ОХУ-ын Ардын жүжигчин Ольга Кошдантай хамт дуулжээ. Санкт-Петербург хотын агаарт Маринский театрын байртай Монгол Улсын төлөөлөгчид "Сайрмон", "Тосон" дууныг хэлж хамт дуулжээ. Тус төлөөлөгчид уран бүтээлчидтэй хамтран ажиллаж буй. Татгалзсан Маринский тайнаа "Тосон" дууныг дуулснаас гурван хөлийн дараа буюу очилдөг Сөлхөн тэрүүний ажилтан Ө.Цэрэнчунт Ольга Кошданыг багтайгаа хамт Н.И.Чайков-



сэй, Ж.Пуччин, Ж.Верди, Э.Вагнер, Р.Штраусын айнаа  
дунд агаарт хамгаалын төлөвлөг-  
дөн бүтээжээ. ОХУ-ын үзэгсэлэн  
хүртээжээ. Эрдмийн театрын  
урлаг ажиллаж буй Ө.Цэрэн-  
чунт ОХУ-д болсон олон  
тэмцээнд амжилттай оролдож,  
төвөр хөлийн дууны дунд  
өндөр үнэлгээг буй бөгөөд  
эно жил эхд хэдэн тэмцээнд  
бэлтгэж байгаа аж.

### ТЕАТР

## Орхон аймгийнхан "Хайрын цэцэрлэг"-ээр зугаалах нь

Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын уран бүтээлчид "Хайрын цэцэрлэг" уялгын жүжгээ өнгөрсөн сард үзэгчдийн хүртээн болгосон. Залуусын үзэгсэлэн өмөрсөн, үнэнч хайр сэтгэлэйн өгүүлдэн эд жүжгийг тус театрынхан МҮОНТ-тэй хамтран дэлгэцийн бүтээх болжээ гээх. Уран бүтээлчид дэлхийн театрын өдрийн утгаж "Хайрын цэцэрлэг"-ийг харуулан аймгагтаа дэний тогтох аж. Мон энэ өдөр Хүүхэд, залуучуудын театр зурван Б.Сайхзавдарын "Цагааг цаг" үзэгсэлэний нээлт болно. Энэ үеэр зурван гурван утгаг дуудлагаар худалдаж, оролгогчид тэдгэр үзэгсэлэн гэгддэг, таан саргай Н.Азжаргал хүүгийн эмчлэлэний зардад хандицах юм байна.

NATIONAL REGISTRATION AND STATISTICS OFFICE

THE WORLD BANK

### INVITATION TO APPLY FOR THE POSITIONS

#### THE WORLD BANK PROJECT CAPACITY ENHANCEMENT OF NRSO

At the request of National Registration and Statistics Office of Mongolia the Government of Mongolia has provided grants for the Capacity Enhancement Project. The project will help the Government of Mongolia track its socio-economic development program and enable high quality and policy relevant data at multiple administrative levels. The National Registration and Statistics Office of Mongolia is now receiving the applications for the part-time following positions:

- Financial management specialist (1 person, part-time basis)**  
The financial management specialist is a part-time position planned for the duration of Capacity Enhancement project implementation. It is expected that the assignment will start on 1 April 2016 and will be completed upon closing of the project. The total working days in one month will be 15 working days.
- Project coordinating and procurement specialist (1 person, part-time basis)**  
The project coordinating and procurement specialist is a part-time assignment planned for the duration of the Capacity Enhancement project implementation. It is expected that the assignment will start from 1 April 2016 and continue till 31 March 2017 with a possibility of extension based on performance evaluation. The total working days in one month will be 15 working days. For more information please send an email to: coordinator\_monsta@nrso.mn or monsta@nrso.mn

The interested applicants are invited to send a Cover letter, Curriculum Vitae and copies of diplomas to the email: coordinator\_monsta@nrso.mn or monsta@nrso.mn

**Deadline for application: 5:00 PM, 28 March 2016.**

### "ШИВЭЭ ОВОО" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛАЛ

2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

"Шивээ Овоо" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуртай 2016 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө хотын 15, Монис шамхаг 14 давхар "Эрдэнэ Монгол" ХХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөвлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх, хараат бүс үндсэн дүгнэлтийг танилцуулах.
- Төлөвлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөвлөн удирдах зөвлөлийн 2016 оны зордлын төслийг хэлэлцэх, батлах.
- Төлөвлөн удирдах зөвлөлийн өрхийн болон хараат бүс гүйцэтгэх сонгох.
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэх, батлах.
- Шинээр нийтэлж худалдаагаар гаргаж, буй хувьцааг хувиаа эзэмшигчид тэрүүгээ ээлжинд худалдан авах дандуу эрх эдүүлэх эрх асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх.

Урагд орлоцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нөрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн 2016 оны 04 дугаар сарын 04-ний өдөрөөр, эцэстэйгэр санал өгөх хувиаа эзэмшигчдийн саналын үндэстэй хувиаа эзэмшигчдийн өдрийн 04 дугаар сарын 28-ны өдрийн өгөөгийн 10.00 цагаар тасалбар болгосон.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн хурлын хэлбэрээр материалтай 2016 оны 04 дугаар сарын 01-ний өдөрөөр дамжуулан танилцан, хураандаа идэвхтэй оролцоно уу.

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө хотын 15